

**ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ  
ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 01 дүгээр  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горим баримталж хэрэгжүүлсэн үйл ажиллагааг харгалзан орон нутгийн төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байх, төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх зарчмыг хангах хүрээнд хэмнэлтийн зарим хязгаарлалтыг уян хатан болгох нь зүйтэй гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нийслэлээс алслагдсан гэдэгт бүх аймгууд болон нийслэлтэй ойр аймгууд хамрагдах эсэх, мөн ижил чиг үүрэг хэрэгжүүлдэг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдэд алслагдсан, алслагдаагүй байдлаар ялгавартай хандах нь оновчтой эсэх, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээвэр, эрчим хүчний салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцсыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамруулж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн үр ашгийг тооцсон эсэх, Багануур, Багахангай, Налайх зэрэг алслагдсан дүүргүүд өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд хамрагдаагүй үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд орон нутгийн хөгжлийн сангаас өвөлжилтийн хүндрэлтэй байдлыг харгалзан эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр тухайн аймаг, сумдад эрх олгох зохицуулалтыг тусгах боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**Д.ТОГТОХСҮРЭН**

